

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Г.Самданцоодол

Утас: 70593208

Цахим хаяг: Samdantsoodolg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .

.....122

Санхүүжилтийн орлого, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаа хоцроож мэдээллэсэн зарим сард мэдээллийг байршуулаагүй.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УСНББОУС

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-02-26

№ 69

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт олгох үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг хэтрүүлэн зарцуулсан, бараа үйлчилгээний бусад зардлаас бэлтгэсэн хөрөнгийг орлогодож аваагүй, шийдвэргүйгээр бусдад шилжүүлсэн, албан хаагч нарт хоолны хөнгөлөлтийг олгохдоо албан томилолттой хугацаанд давхардуулан тооцож олгосон зэрэг зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих/, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 5.1 дэх хэсгийн 2-д /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч- 5.0 сая төгрөг хүртэл/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т /Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ:/ 2.2.1. /унааны зардал;/ 2.2.2/байрны зардал;/ 2.2.3 /хоолны зардал/заасныг тус тус зөрчсөн. Аудитаар илэрсэн дээрх нийт залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 4,832.4 мянган төгрөгөөр их байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тайлант онд хэлмэгдэгсдийн ар гэр, төрөл төрөгсдөд улсаас олгох тэтгэмжийг дансаар дамжуулан олгож, санхүүгийн тайланд толилуулан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 хөтөлбөр зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,054,319.00</u>	<u>22,107,234.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	14,054,319.00	18,257,119.00
354	Хангамжийн материал	14,054,319.00	18,257,119.00
35410	Бичиг хэргийн материал	263,500.00	2,125,300.00
35420	Аж ахуйн материал	13,790,819.00	16,131,819.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>253,160,117.41</u>	<u>206,912,752.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	253,160,117.41	206,912,752.25
392	Биет хөрөнгө	250,229,117.45	203,185,196.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	226,155,000.00	226,155,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(106,402,499.88)	(146,319,999.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,123,213.00	186,104,713.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,092,631.18)	(67,606,798.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,619,402.76	33,619,402.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,173,367.25)	(28,767,120.95)
393	Биет бус хөрөнгө	2,930,999.96	3,727,555.49
39301	Програм хангамж	308,000.00	1,881,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(77,000.04)	(178,444.51)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,600,000.00	3,600,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(900,000.00)	(1,575,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>267,214,436.41</u>	<u>229,019,986.25</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>267,214,436.41</u>	<u>229,019,986.25</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	267,214,436.41	229,019,986.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	166,199,019.00	166,199,019.00
51101	Өмч: - төрийн	166,199,019.00	166,199,019.00
512	Хуримтлагдсан үр дүн	100,412,188.86	62,217,738.70
51210	Өмнөх үеийн үр дүн	100,412,188.86	100,412,188.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	603,228.55	603,228.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>267,214,436.41</u>	<u>229,019,986.25</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	675,334,500.00	989,600,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	675,334,500.00	986,000,100.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	179,935,000.00	294,380,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	179,935,000.00	294,380,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	495,399,500.00	691,620,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	495,399,500.00	691,620,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	722,063,244.73	1,035,783,165.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	722,063,244.73	1,035,783,165.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,576,477.88	913,597,647.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,826,173.00	248,037,255.56
210101	Үндсэн цалин	113,961,845.00	152,610,300.67
210102	Нэмэгдэл	30,373,933.00	67,831,526.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,790,000.00	7,475,100.00
210104	Урамшуулал	14,700,395.00	20,120,328.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,239,037.00	30,132,174.83
210201	Тэтгэврийн даатгал	14,095,235.96	21,083,166.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,658,261.73	2,480,372.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,326,609.42	1,984,298.02
210204	Ажилгүйдлийн даатгал	287,175.35	416,758.03
210205	Эрүүл мэндийн даатгал	2,871,754.54	4,167,579.48
2104	Хангамж, бараа материалын зардал	32,113,242.00	34,692,750.10
210401	Бичиг хэрэг	2,362,000.00	2,313,150.00
210402	Тээвэр, шатахуун	24,698,674.00	26,649,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,432,728.00	705,920.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,619,840.00	5,024,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,499,210.00	18,350,000.00
210604	Урсгал засвар	14,499,210.00	18,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,753,000.00	10,908,000.00

210702	Дотоод албан томилолт	5,753,000.00	10,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,819,596.15	145,925,093.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,494,146.15	141,814,823.12
210803	Даатгалын үйлчилгээ	133,650.00	3,133,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,800.00	287,620.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,326,219.73	425,552,373.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,524,195.00	295,453,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,474,250.00	54,967,448.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,327,774.73	75,131,865.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,486,766.85	122,185,517.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,967,900.00	6,500,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	3,600,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,767,900.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	518,866.85	15,936,062.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	518,866.85	15,936,062.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(46,728,744.73)	(46,183,065.16)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,485,319.59	660,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,485,319.59	660,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(12,485,319.59)	(660,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(59,214,064.32)	(46,843,065.16)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	675,334,500.00	989,600,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	675,334,500.00	986,000,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	179,935,000.00	294,380,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	179,935,000.00	294,380,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	495,399,500.00	691,620,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	495,399,500.00	691,620,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	648,191,200.00	964,854,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,191,200.00	964,854,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,704,433.15	842,668,582.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,826,173.00	248,037,255.56
210101	Үндсэн цалин	113,961,845.00	152,610,300.67
210102	Нэмэгдэл	30,373,933.00	67,831,526.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,790,000.00	7,475,100.00
210104	Урамшуулал	14,700,395.00	20,120,328.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,239,037.00	30,132,174.83
210201	Тэтгэврийн даатгал	14,095,235.96	21,083,166.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,658,261.73	2,480,372.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,326,609.42	1,984,298.02
210204	Ажилгүйдлийн даатгал	287,175.35	416,758.03
210205	Эрүүл мэндийн даатгал	2,871,754.54	4,167,579.48
2104	Хангамж, бараа материалын зардал	32,162,972.00	37,341,350.10
210401	Бичиг хэрэг	2,253,000.00	2,799,950.00
210402	Тээвэр, шатахуун	24,410,754.00	26,649,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,432,728.00	705,920.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,066,490.00	7,185,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,499,210.00	18,350,000.00
210604	Урсгал засвар	14,499,210.00	18,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,753,000.00	10,908,000.00
210702	Дотоод албан томилолт	5,753,000.00	10,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,225,596.15	145,925,093.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	213,900,146.15	141,814,823.12
210803	Даатгалын үйлчилгээ	133,650.00	3,133,650.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,800.00	287,620.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,998,445.00	351,974,708.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,524,195.00	295,453,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,474,250.00	56,521,648.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,486,766.85	122,185,517.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,967,900.00	6,500,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	3,600,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,767,900.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	518,866.85	15,936,062.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	518,866.85	15,936,062.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,143,300.00	24,746,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,143,300.00	23,571,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,143,300.00	23,571,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,143,300.00	23,571,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,143,300.00	23,571,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(27,143,300.00)	(23,571,500.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	166,199,019.00	603,228.55	85,236,113.18	252,038,360.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	166,199,019.00	603,228.55	85,236,113.18	252,038,360.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	166,199,019.00	603,228.55	85,236,113.18	252,038,360.73
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	166,199,019.00	603,228.55	85,236,113.18	252,038,360.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	166,199,019.00	603,228.55	85,236,113.18	252,038,360.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(38,194,450.16)	(38,194,450.16)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	166,199,019.00	603,228.55	47,041,663.02	213,843,910.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	691,620,200.00	675,684,037.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	691,620,200.00	675,684,037.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585,370,200.00	569,434,582.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,087,900.00	248,037,255.56
210101	Үндсэн цалин	154,478,000.00	152,610,300.67
210102	Нэмэгдэл	68,026,000.00	67,831,526.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,523,600.00	7,475,100.00
210104	Урамшуулал	18,060,300.00	20,120,328.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,287,300.00	30,132,174.83
210201	Тэтгэврийн даатгал	21,060,400.00	21,083,166.71
210202	Тэтгэмжийн даатгал	2,477,700.00	2,480,372.59

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,982,200.00	1,984,298.02
210204	Ажилгүйдлийн даатгал	433,500.00	416,758.03
210205	Эрүүл мэндийн даатгал	4,333,500.00	4,167,579.48
2104	Хангамж, бараа материалын зардал	37,354,300.00	37,341,350.10
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,799,950.00
210402	Тээвэр, шатахуун	26,650,000.00	26,649,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	717,900.00	705,920.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,186,400.00	7,185,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,366,300.00	31,355,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,016,300.00	13,005,000.00
210604	Урсгал засвар	18,350,000.00	18,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,908,000.00	10,908,000.00
210702	Дотоод албан томилолт	10,908,000.00	10,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142,116,400.00	142,111,593.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	138,006,000.00	138,001,323.12
210803	Даатгалын үйлчилгээ	3,133,700.00	3,133,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,700.00	287,620.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	645,000.00	645,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,250,000.00	69,549,208.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,027,600.00	13,027,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,222,400.00	56,521,648.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,250,000.00	106,249,455.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	99,750,000.00	99,749,455.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	99,750,000.00	99,749,455.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	6,500,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	3,600,000.00	3,600,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	900,000.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	691,620,200.00	675,684,037.41
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	691,620,200.00	691,620,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	691,620,200.00	691,620,100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	10.00	10.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АШ тоо	Тоо	Дүн	
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг олгохдоо зардлын хязгаараас хэтрүүлэн зарцуулсан.	1	11,188.4	1	11,188.4									
Албан хаагч нарт хоолны хөнгөлөлтийг олгохдоо албан томилолттой хугацаанд давхардуулан тооцож олгосон	1	451.8	1	451.8									
Бараа үйлчилгээний бусад зардлаас бэлтгэсэн хөрөнгийг орлогодож аваагүй, шийдвэргүйгээр бусдад шилжүүлсэн.	1	3,550.0			1	3,550.0							
Төсвийн зардлыг зориулалт бусаар, гүйцэтгэлд үндэслэлгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, хяналтгүй зарцуулсан.	1	-			1	-							
Дүн	4	15,190.3	2	11,640.2	2	3,550.0							

Санхүүгийн тайлангийн нийцлийн асуудлын нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Төсвийн шууд захирагч нь өөртөө шийдвэр гаргаж үр дүнгийн урамшуулал тооцуулсан.	1	310.6			1	310.6						
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны албан хаагчид болон иргэдийн Хурлын төлөөлөгч нар гадаад сургалтад хамрагдахаар БНСУ-ын Сүүл хот, БНХАУ-ын Хөх хотод агаарын тээврээр зорчихдоо үндэсний тээвэрлэгч компаниар үйлчлүүлээгүй.	1	-			1	-						
Дүн	2	310.6			2	310.6						